



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/30

Хажуу шинэ-Ус

2023 оны нэгдүгээр ээлжийн цэрэг татлага
явуулах тухай

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6, Аймгийн Засаг даргын 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/208 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2023 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагыг 2023 оны 04 дүгээр сарын 23-ний өдрийн 09:00 цагт Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд зохион байгуулсугай.

2. Цэрэг татлага зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч : Н.Өлзийтогтох (Засаг даргын Тамгын газрын дарга)
Гишүүд
Э.Лайжинханд (Архив, бичиг хэргийн эрхлэгч)
Э.Ванчиндорж (Хэсгийн төлөөлөгч)
П.Цэцэгмаа (Бага эмч)
Б.Гүнсэнтүг (1 дүгээр багийн Засаг дарга)
Г.Батчулуун (2 дугаар багийн Засаг дарга)
Б.Даваасүрэн (3 дугаар багийн Засаг дарга)
Л.Батбаатар (4 дүгээр багийн Засаг дарга)
А.Бямбасүрэн (Их эмч)

3. Цэрэг татлагын товчоогоор орох цэргийн насны залуучуудад зарлан дуудах мэдэгдлийг албан ёсоор хүргүүлж иргэдээ бүрэн хамруулж 5-аас дээшгүй залуучуудыг үзлэгт нэг дор оруулан зохион байгуулахыг хэсгийн төлөөлөгч Э.Ванчиндорж, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4. Цэрэг татлагын байрыг журмын дагуу бэлтгэхийг ажлын хэсгийн ахлагч (Н.Өлзийтогтох)-д даалгасугай.

5. Тус үйл ажиллагааны зардал 200,000 (Хоёр зуун мянга) төгрөгийг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (У.Сүнжидмаа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Т.АРИУНАА

